




IT'S JANUARY 1
2020

HAPPY NEW YEAR!

Wishing you have the best one yet!

Happy holidays from Susanne and Me. Wishing all the Best to You and Your Family.



SEASON'S GREETINGS



Holger and Susanne Knaack
2020-21 PRESIDENT
ROTARY INTERNATIONAL

Танд болон Танай Гэр Бүлд Сузан бид 2ын зүгээс Баяр Хөөртэй Шинэ Оны Мэнд Дэвшүүлж Хамгийн Сайн Сайхан Бүхнийг Хүсэн Ерөөе!

Холгэр Наак
Олон Улсын Ротарийн 2020-2021 оны Ерөнхийлөгч

ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН ЗАХИРАГЧ ЭРИК ЧАКИЙН МЭНДЧИЛГЭЭ



Бид бусдад итгэл найдвар төрүүлэх хэн нэгэн нь болох ёстой. Эргэн тойрондоо болон өөрсдөдөө өөрчлөлтийг тогтвортой бий болгох, түүнийг үргэлжлүүлэх нь бидний хувьд үнэт зарчим. Спорт арга хэмжээг зохион байгуулж Ротаричууд, Ротарактууд болон найз нөхдийнхөө хүрээнд “End Polio” аяныг дэмжсэн та бүхэнд баярлалаа.

Монголд Ковид-ын тохиолдол эрс нэмэгдсэн цаг үед Монголын Ротаричууд үүссэн нөхцөл байдалд туслах хандивын үйл ажиллагааг санаачилж ХонгКонг, Масао Монголын Ротаричууд цаг алдалгүй дэмжин онцгой бүсэд хэрэгцээтэй хамгаалалтын хувцас хэрэгсэл болон шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан 30,000 гаруй ам. долларын сан босгож чадлаа. Мөн Улаанбаатар Ротари клуб дэргэдэх Хөгжлийн Ротари сангаар дамжуулан Ковид цар тахлын эсрэг үйл ажиллагаанд нэгдэж ЭМЯаманд 100 сая төгрөгийг гардуулан өгсөн байна.

Мөн энэ жилийн томоохон төслүүд бол Хүрээ Ротари клубийн 227,800 ам. доллар өртөг бүхий бөөрний чулуу хайлуулах лазер аппаратыг Улсын 1-р эмнэлэгт хүлээлгэн өгсөн төсөл болон Улаанбаатар Ротари клубийн 170 сая төгрөг өртөг бүхий эмнэлгийн аюултай хог, хаягдал устгах төхөөрөмж хоёр ширхгийг Эрүүл мэндийн яаманд гардуулан өгсөн төсөл юм.

Монголын нийт Ротарактуудын хамтдаа санаачлан хэрэгжүүлсэн “Бяцхан баатрууд” төслийн аяны үр дүнд зорилтот бүлгийн 400 гаруй өрхөд хүнсний бүтээгдэхүүн хүүхдийн бэлэг хандивлажээ. Дүүргийн болон бүсийн Ротаричууддаа энэхүү чухал төсөлд хандив өгсөнд талархал илэрхийлье.

Монголын нийт Ротарийн гишүүддээ үйл ажиллагааныхаа нэг хэсгийг цар тахлын эсрэг нэгдэн зориулж ажилласанд дахин талархал илэрхийлж байна.

Би үнэхээр та бүхнээр маш их бахархаж байна, удахгүй 2021 оны 5-р сард уулзана гэдэгтээ найдаж байна.

Бүгдэд нь энх тайван, эрүүл энх, боломжоор дүүрэн гайхалтай 2021 оны мэндийг хүргэж байна.

Эрик Чак

Олон Улсын 3450 Дүүргийн Захирагч

ОЛОН УЛСЫН РОТАРИ 3450 ДҮҮРГИЙН 9, 10 БҮСИЙН ЗАХИРАГЧ НАРЫН МЭНДЧИЛГЭЭ



Happy Holidays! All The Best to You and Your Families!

D. Damdindorj
Assistant Governor, Area 10
District 3450, Rotary International

L. Bat-Erdene
Assistant Governor, Area 9
District 3450, Rotary International

Сайн байцгаана уу

Эрхэм хүндэт үе үеийн Бүсийн захирагч, Бүсийн удирдлага, Клубуудийн Ерөнхийлөгчид болон Ротари гэр бүлийн гишүүдээ, 2020-21 оны Ротари жил тал дундаа орж та бид хагас жилийн турш хийж бүтээсэн зүйлсээ дүгнэх, дараагийн хагас жилийн бэлтгэлээ хангах, ирээдүйн манлайлагч нараа бэлтгэх, сургах, төлөвлөх хэсэг рүү орж байна.

Энэ жилийн хувьд бид бүхний хүсэн хүлээж, цуглардаг Шинэ жилийн баяр онцгой нөхцөл байдлын учраас цуцлагдан, тодорхойгүй нөхцөлд шилжсэн хэдий ч олон ажлыг амжуулсан, дор бүрнээ эерэг зүйлсийг түгээсэн, улам нэгдэж нягтарсан өдрүүдийг өнгөрөөж байна.

Орон нутгийн Ротари клубүүдээ дэмжих, цаг үеийн байдалд хариу үзүүлэх хандивын аян эхлүүлсэн нь улам өргөжиж, Дүүрэг болон бүсийн дэмжлэгээр маш амжилттай маш олон хүнд үр өгөөжөө өгсөн арга хэмжээ боллоо. Олон жилийн өмнөх төслүүд өнөөдрийг хүртэл үр ашгаа өгч байгаагийн адил урт хугацаанд үргэлжлэн хэрэгжих олон төслүүдийн эхлэл тавигдлаа.

Бидний гэр бүл өргөжин тэлэх тусам олон гишүүдийн ажил төрөл, бизнес бусад мэдээллийг илүү цэгцтэй, нэгдсэн байдлаар танилцуулах шаардлага, хэрэгцээ бүх гишүүдийн судалгаанаас дүгнэгдэж байна. Энэ жил анх удаа Rotary mean business – Rotary Global Reward хөтөлбөр, арга хэмжээг эхлүүллээ. Мөн шинэ гишүүдэд зориулсан сургалтууд илүү олон хувилбараар, хялбар байдлаар зохион байгуулагдах боломжтой болж байна. “Ротари – Боломжуудыг Нээнэ” гэсэн уриатай энэ жилийн хувьд бид нийгэмд үйлчлэх олон боломжуудаас гадна гишүүдэд чиглэсэн боломжуудыг нээж, хамтран ажиллахаар төлөвлөж байна.

“Өөрөөсөө Давж Бусдад Үйлчлэх” сэтгэлтэй та бүхэн энэ онцгой нөхцөл байдалд гэр гэртээ, гэр бүлээрээ эрүүл энх, аз жаргалтай байхыг хүсэн мэндчилж байна.

Хүндэтгэсэн,
9 дүгээр бүсийн захирагч Л.Бат-Эрдэнэ
10 дугаар бүсийн захирагч Д.Дамдиндорж



ОЛОН УЛСЫН РОТАРИЙН 3450 ДҮҮРГИЙН 9, 10 БҮСИЙН 2020-2021 ОНЫ УДИРДЛАГЫН БАГ

Олон Улсын Ротарийн 3450 9-р Бүсийн Захирагч АГ Л. Бат-Эрдэнэ, 10-р Бүсийн Захирагч АГ Д. Дамдиндорж нар 2020-2021 оны Ротарийн жилд дараах бүрэлдэхүүнтэй удирдлагын багтай хамтран ажиллаж байна: 9-р бүсийн DAG Б. Сальма, 9-р бүсийн DAG П. Чимэдням, 10-р бүсийн DAG Ж. Галбадрах, 10-р бүсийн DAG Т. Болормаа, 9,10 бүсийн DDS Н. Мягмаржаргал, 9-р Бүсийн DDS М. Шүрэнцэцэг, 10-р бүсийн DDS П. Ганцэцэг, 9, 10 бүсийн Зөвлөх PAG Ч. Энхтуяа, Санхүүч PP Х. Уранхайч, Ротари Сангийн хорооны дэд дарга, PAG Б. Булган, Гишүүнчлэлийн хорооны дэд дарга, PAG Г.

Цэрэнчимэг, Сургалтын хорооны дэд дарга IPAG А. Мөнхжаргал, PI хорооны дэд дарга Э. Ганбат, Эрхтэн шилжүүлэн суулгах хорооны дэд дарга PAG Д. Бэрцэцэг, Энхтайвны хорооны дэд дарга PAG Ц. Ганзориг, Залуучуудыг дэмжих хорооны дэд дарга PP Х. Ариунгоо болон Н. Кермен, Эрүүл мэндийн хорооны дэд дарга DAG Т. Болормаа, IT хорооны дэд дарга PP Б. Эрдэнэбаяр, Эх Дэлхийгээ хамгаалах хорооны дэд дарга PP Г. Ууганбат, Ротари Мэдээллийн Төвийн дарга PAG Д. Бэрцэцэг.

9, 10 БҮСИЙН ЗҮҮСГЭЛ СОЛИЛЦОХ, ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ЁСЛОЛ

Жил бүрийн 7-р сарын 1 нд дэлхий дахинаа Ротарийн бизнесийн шинэ жил эхэлж өмнөх жилийн удирдлагын баг ажлаа дүгнэн дараа жилийн багтайгаа зүүсгэл солилцож ёслол зохион байгуулдаг. Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9 болон 10-р бүсийн Зүүсгэл солилцох үйл ажиллагааны амжилттай зохион байгуулагдаж бүсийн удирдлага болон клубүүдийн Ерөнхийлөгч нар ажил үүргээ хүлээлцсэн сайхан өдөр болсон. Жил ирэх тусам уг арга хэмжээ нь илүү том цар хүрээтэй болж олон Ротаричууд оролцдог хүлээлт бүхий бидний арга хэмжээ болсоор байна.



ДҮҮРГИЙН ЗАХИРАГЧИЙН ВИРТУАЛ УУЛЗАЛТУУД

Жил болгон уламжлал ёсоор 8 сард Дүүргийн захирагч өөрийн удирдлагын багын хамт Монголд албан ёсны айлчлал хийж клубүүдийн ерөнхийлөгч болон гишүүдтэй танилцдаг билээ. Энэ жилийн нөхцөл байдлын улмаас

биелэн ирэх боломжгүй байсан тул 2020 оны 8 сарын өдөр жил Цахимаар албан уулзалтуудыг зохион байгуулсан. Нийт 16 Ротари клубүүд өөрсдийн 2020-2021 оны төлөвлөгөөгөө танилцууллаа.



ORGAN DONATION ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

"Organ Donation" Хорооны дэд дарга PAG Бэрцэцэг "Амьгүй Донороос Эд Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг өргөжүүлэх нь" олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцож мэдээлэл хийлээ.



РОТАРИ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭ ЧИГЛЭЛ: ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАМГААЛАХ ХОРОО

Ротари Сангийн болон Олон Улсын Ротари ТУЗ санал хураалтаар шинэ Олон Улсын Ротарийн Үйл Ажиллагааны Чиглэл болох 7 дахь Чиглэлийг "Байгаль Орчныг Хамгаалах" болгон баталж шийдвэрлэсэн Сүүлийн 5 жилийн хугацаанд 18 сая ам.доллар байгаль орчинтой холбоотой Глобал Грант төслүүдэд хуваарьлагдаж байсан ба сүүлийн жилүүдэд Монголын Ротари клубууд ч нилээд олон төслүүдийг энэ чиглэлд хэрэгжүүлсэн байдаг. 2020 оноос Олон Улсын 3450 дүүрэг дээр Preserve Planet Earth буюу /Эх дэлхийгээ хамгаалах/ хороо байгуулагдан Монголын 9,10-р бүсээс 12 клуб Ногоон клуб болох болзлоо ханган клуб дотроо PPE Ambassador/Representative буюу Элч төлөөлөгчөө томилон ажиллаж байна.



Дүүргийн уриа ба зорилго: Ногоон клуб болцгооё!



ЭМГЭНЭЛ



Монголын Ротари Хөдөлгөөний анхдагчдын нэг, хүмүүнлэгийн үйлст үлгэрлэн манлайлагч, Монголын Ротарийн 25 жилийн бахархалт түүхүүдийг тод томруунаар бүтээлцэж ирсэн, Олон улсын Ротарийн 3450 дүүргийн 10-р бүсийн харьяа “Хүрээ Ротари” клубын үүсгэн байгуулагч - анхны ерөнхийлөгч, Олон улсын Ротари Сангийн Хүндэт хандивлагч, Бүсийн Захирагч (2008-2009 он) **Ж.ОЮУНГЭРЭЛ** нь өвчний улмаас таалал төгсөж Монголын Ротаричуудад хүнд гарз тохиолоо.

Ж.ОЮУНГЭРЭЛ нь Ротарийн үзэл баримтлалд тууштай байж өөрийн цаг хугацаа, чин сэтгэл, холч ухаан, үнэт зүйлсээ Ротаригаар дамжуулан бусдад харамгүй зориулахдаа энэ дэлхий дээр амьдрахын утга учир бол бусдад туслах явдал болохыг тунхаглаж чадсан ёс зүйтэй, хамтран зүтгэгч биднийхээ хүндлэл бахархалыг хүлээсэн эрхэм нэгэн гишүүн маань байлаа. Тэрээр Монголынхоо болон дэлхийн 1.2 сая Ротаричуудын нэгэн хүндтэй гишүүн нь байж, улс орныхоо төдийгүй олон улсад тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд хүнлэг сэтгэлээр хандаж, Ротарийн гишүүний үүргээ нэр төртэй биелүүлж чадсан, бидний бахархал болсон хүмүүнлэгийн бахархам үйлстэн байсан.

Монголын Ротарийн эгэлгүй үйлстэн, эгэл даруу түүний хийж бүтээсэн их үйлс Монголын Ротаричууд бидний сэтгэлд үүрд хоногшин үлдэх болно.

УМ МА НИ БАД МЭ ХУМ



**ОЛОН УЛСЫН РОТАРИЙН
3450 ДҮҮРГИЙН 9 & 10 ДУГААР БҮС**

УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ

2020-2021 Ерөнхийлөгч С.Энхтуяа

ХАМГААЛАХ ХЭРЭГСЛИЙН БАГЦЫГ ХӨСҮТ-Д ХАНДИВЛАВ.

2020 оны 9 сарын 12-ны өдөр Улаанбаатар Ротари клуб Ротари сангийн санхүүжилттэй хэрэгжүүлж байгаа “Эрхтэн шилжүүлэн суулгах чадавх сайжруулах” төслийн хамтрагч Солонгосын Ротари клубтэй хамтран КОВИД19 өвчний тэргүүн шугаманд ажиллаж байгаа эмч сувилагчдад зориулан яаралтай тусламж, хувийн хамгаалах хэрэгслийн 6,500,000 төгрөгийн багцыг ХӨСҮТ-д гардуулж өглөө.

ТУСГАЙ ОЛИМПИЙН ТАМИРЧДЫГ ДЭМЖИХ



Улаанбаатар Ротари клубийнхэн 8 настай дауны синдромтой хүүхэд зурсан хөөрхөн туулайны хөрөгтэй болсон. Энэхүү бүтээл нь тусгай олимпийн тамирчдыг дэмжих хөрөнгө босгох арга хэмжээнд тавигдсан энэ бүтээлийн эзэнд тал мөнгө нь очиж тал мөнгө нь оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгай олимпд бэлтгэх үйлсэд зарцуулагдана. Тусгай олимп гэдэг нь спортын уралдаан тэмцээнээр дамжуулж оюуны бэрхшээлтэй хүүхэд залууст урам зориг өгөх, бие бялдрыг нь хөгжүүлэх, тэднийг бусадтай адил тэгш эрхтэй иргэн гэдгийг олон нийт, нийгэмд таниулах зорилготой олон улсын хүмүүнлэгийн хөдөлгөөн юм. Тусгай олимп нь олон улсын хэмжээнд явагддаг бөгөөд манай Монгол хүүхдүүд амжилттай оролцож энэ олимпын аварга болж эх орныхоо нэрийг дурсгаж байсан түүхтэй.



МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН РОТАРИ САНГААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ОНЦГОЙ КОМИССТ 100,000,000 ТӨГРӨГИЙН ХАНДИВ

Монгол Улс, Улаанбаатар хот – Монголын Хөгжлийн Ротари сангаас Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой Комиссоос КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн хандивыг гардуулан өглөө. Эрүүл мэндийн яамтай зөвшилцсөний үндсэн дээр энэхүү хандиваар Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв (ХӨСҮТ)-д нийслэл, орон нутгаас цуглуулж байгаа КОВИД-19 илрүүлэх молекул биологийн (PCR) хамар залгиурын арчдасаас сорьц авах бамбар 100,000 (нэг зуун мянга) ширхэг, хуруу шил 200,000 (хоёр зуун мянга) ширхгийг тус тус худалдан авах юм. ХӨСҮТ нь КОВИД-19 цар тахлын дэгдэлттэй холбоотой уг өвчнийг цаг алдалгүй оношлох, илрүүлэг, тандалт, хавьтлын шинжилгээг хийж, аймаг, дүүргүүдийн урвалж, оношлуурын бэлэн байдлыг ханган ажиллаж байгаа юм.

ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ, ХАЯГДАЛ УСТГАХ ТӨХӨӨРӨМЖ

КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн энэ цаг үед эмнэлгийн аюултай хог хаягдлыг стандартын дагуу устгах нь чухал ач холбогдолтой юм. Иймд “Улаанбаатар Ротари клуб” өөрийн түнш болох Франц улсын “Парис Ротари клуб”-тэй хамтран эмнэлгийн аюултай хог, хаягдал устгах төхөөрөмж хоёр ширхгийг Францын Санодев (Sanodev) компанид захиалан үйлдвэрлүүлж, Эрүүл мэндийн яаманд гардуулан өглөө. Тус бүр нь 39,213 (гучин есөн мянга, хоёр зуун арван гурав) евро буюу нийт 78,426 (далан найман мянга, дөрвөн зуун хорин зургаа) еврогийн үнэ бүхий эдгээр төхөөрөмжийг Сэлэнгэ аймгийн Мандал, Өмнөговь аймгийн Сэврэй сумдын Нэгдсэн эмнэлэгт хуваарилах юм.

КОВИДЫН ЭСРЭГ РОТАРИЧУУД НЭГДЭЖ БАЙНА!

2020-11-р сарын 15 Монгол улсад Ковид19 цар тахлын тохиолдол нэмэгдэж бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, хатуу хөл хорионы дэглэм тогтоосон онцгой нөхцөл байдалд албан үүргээ гүйцэтгэж буй мэргэжлийн байгууллага, алба хаагчдыг хамгаалах хэрэгслээр дэмжих, туслах зорилгоор Монголын Ротаричууд хандивын арга хэмжээ санаачлан эхлүүлсэн.

Энэхүү сайн санааны хандивын арга хэмжээнд Олон улсын Ротарийн 3450 Дүүрэг, ХонгКонг, Масао болон Монголын 9, 10-р Бүсийн Ротаричууд санаачлагатай оролцож нийтдээ 82,700,000 төгрөгийн хандив цугларсан байна.

Энэхүү хандиваар Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой Комиссоос Ковид19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор халдвар-хамгааллийнхувцас, амны хаалт, ариутгалын бодис, гар ариутгагч болон улсын томоохон эмнэлгүүд болох ХӨСҮТ-д монитормын аппарат, ХСҮТ болон Эх нялхсын төв -д хүчилтөрөгч өтгөрүүлэгч, УНЭ-т 9 сая төгрөгийн үнэ бүхий “Safe Gate” халдваргүйжүүлэх үйлчилгээтэй хаалга зэрэг нэн шаардлагатай байгаа эд хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авч хандивлаж байна.

Дараагийн ээлжинд өрхийн эмнэлгүүдэд гар ариутгагч төхөөрөмж хандивлахаар боллоо.

Rotary

COVID-19

#RotaryResponds



ХҮРЭЭ РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Б.Бадамсүрэн

ТОГТМОЛ ХУРЛУУД: 20

Хүрээ клубийн 20 тогтмол уулзалтуудаас 14 удаагийн уулзалт нь зочинтой, 2 удаагийн уулзалт нь цахимаар зохион байгуулагдсан.



ШИНЭ ГИШҮҮН

2020-21 оны Ротарийн жилд Доржийн Энхжаргал гэдэг эмч мэргэжилтэй шинэ гишүүнийг элсүүлсэн. Ментор нь 2020-21 оны Ерөнхийлөгч Б.Бадамсүрэн. 2020 оны 8-р сард бүсээс зохион байгуулсан шинэ элсэх сонирхолтой хүмүүст зориулсан сургалтад хамруулсан.

ХҮРЭЭ КЛУБЫН ЦААШДЫН ЗОРИЛТ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ РР НАРЫН УУЛЗАЛТ

Хүрээ Ротари клубийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан, одоо клубийн гишүүн хэвээр байгаа РР нарын уулзалтыг зохион байгуулж, клубийн үйл ажиллагаа, цаашдын зорилтын талаар зөвлөлдсөн.



DG ВИРТУАЛ УУЛЗАЛТ: 8 БОАРД ГИШҮҮН

2020-21 оны клубын Боардын гишүүд дүүргээс зохион байгуулсан цахим сургалт, дүүргийн Ерөнхийлөгчийн вертуаль айлчлалд оролцсон.



ДҮҮРГИЙН ЗУРГИЙН УРАЛДААН

Зургийн уралдаанд хандивын үйл ажиллагаа, төслийн хэрэгжүүлэх үйл явцын зургуудаар оролцсон.



ГИШҮҮДИЙН АЖИЛТАЙ ТАНИЛЦАХ

Клубийн Ерөнхийлөгч Б.Бадамсүрэн, гишүүн Т.Амартүвшин нарын ажлын байранд клубийн уулзалтыг зохион байгуулж, гишүүдийн эрхэлдэг үндсэн ажилтай танилцуулан, шинэ мэдээллээр гишүүдийг хангасан.



ХҮРЭЭ КЛУБЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ АЯЛАЛ

Жил бүр уламжлал ёсоор зохион байгуулагддаг энэхүү аялал нь 2020-21 онд Архангай аймгийн Ихтамир сумын нутагт оршдог байгалийн үзэсгэлэнт Хөх нуурын чиглэлд зохион байгуулсны зэрэгцээ Ихтамир сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлэгт ариутгалын бодис, гар ариутгагч, маск, хичээлийн хэрэгсэл зэрэг 6 сая гаруй төгрөгийн өртөг бүхий “Ковидын Эсрэг Хамтдаа” төсөл хэрэгжүүлсэн. Төсөлд нийгмийн хариуцлагатай Пролианс ХХК, Эмэдюс ХХК-ууд оролцсоны зэрэгцээ РР Д.Сэргэлэн, РР С.Алимаа, Залуучуудын хорооны дарга Б.Батзориг, Сангийн хорооны дарга Д.Чулуунбаатар, Дэг сахиулагч Б.Алтанбаяр нар хандив өргөн оролцсон.



GG2098544 ДУГААРТАЙ “ЛАЗЕРААР БӨӨРНИЙ ЧУЛУУ ХАЙЛУУЛАХ” ТӨСӨЛ

Gg2098544 дугаартай “ЛАЗЕРААР БӨӨРНИЙ ЧУЛУУ ХАЙЛУУЛАХ” 237,000\$ өртөг бүхий төслийг олон улсын Ротарийн 3450 дүүрэг, Японы Tokyo-Arakawa, Taehikawa Kobushi, Teudo-East, олон улсын Ротарийн 2800, 2580, 2750 дүүргүүдтэй хамтран амжилттай хэрэгжүүлэн тоног төхөөрөмжийг УКТЭ-ийн Урологи андрелогийн төвд хүлээлгэн өгсөн.

ШИНЭ МОНГОЛ МАБУЧИ САНГИЙН ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Энхүү хөтөлбөрийг эргэн төлөгдөх нөхцөлтэй сургалтын тэтгэлэгийг 2015 оноос 5 оюутанд олгосон. Энэ онд оюутан М.Өсөхбаяр тэтгэлэгт хамрагдахаар шалгарсан бөгөөд Мобучи сангийн 5 жилийн ойн арга хэмжээн дээр РР Ли Сын Мин, Санхүүч Л.Мөнхболд нар эрхийн бичгийг гардуулж өгсөн.



БҮСИЙН БОЛОН КЛУБУУДЫН ТӨСЛҮҮДИЙГ ДЭМЖЭХ

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын аюул Монгол улсад үүссэнээс үүдэн Монголын “Ротаричууд Ковидын Эсрэг” хүчээ нэгтгэцгээхэд болон Зуунмод Ротари клубийн санаачилсан “Зуунмод-Зуун Хүүхэд” төсөлд тус тус оролцсон.



ЗУУНМОД РОТАРИ КЛУБ

2020-2021 оны Ерөнхийлөгч Д. Мияажав

- Олон Улсын Ротарийн 3450 Дүүргийн 9 болон 10-р бүсийн Зүүсгэл солилцох үйл ажиллагааны үеэр Зуунмод Ротари клуб нь хуучин гишүүдээ хэвээр хадгалж мөн шинээр 3 гишүүн клубтээ элсүүлсэн амжилтаар Гишүүнчлэлийн Хорооны болон Сангийн Хорооны шагнал болох тус бүр 100,0₮ өргөмжлөл гардан авсан нь гишүүд, дэмжигчдийн хувьд урам өгсөн сайхан үйл явдал болсон.

- 2020 оны 7 сарын 5нд Клубийн Ерөнхийлөгч Мияажав өөрийн удирдлагын багийн бүрэлдэхүүний хамт клубийн зүүсгэл солилцох үйл ажиллагаа зохион байгуулж өнгөрсөн жилийн ажлаа дүгнэж, ирэх Ротарийн жилд хамтран хийж хэрэгжүүлэх ажил болон зорилтуудаа тодорхойлов

- Бүсийн Захирагч нар болон удирдлагын баг, Гишүүнчлэлийн Хороо хамтран зохион байгуулсан "Ротарийг танилцуулах өдөрлөг"-т клубийн гишүүн РАГ Бэрцэцэг оролцож Ротари гэж юу вэ, "Ротарийн боломжууд" сэдвээр ариа танилцуулга хийж оролцлоо.

- ОУР-ын 3450 Дүүргээс Онлайн хэлбэрээр зохион байгуулсан гишүүнчлэлийн хорооны форумд клубийн 2 гишүүн амжилттай оролцлоо

- Зуунмод Ротари клубийн Ерөнхийлөгчөөр сонгогдсон Д. Мияажав клубийн удирдлагын багийн 5 гишүүний хамт уулзалт-ярилцлаганд оролцлоо.

СПОРТЛОГ РОТАРИЧУУД

ОУ-ын Ротарийн 3450 Дүүргийн 9 болон 10-р бүсийн Бүсийн Ротари клубуудын дунд уламжлал болон зохиогддог спортын арга хэмжээнд Зуунмод Ротари клуб амжилттай оролцож дартс эмэгтэй төрөлд алтан медаль, дартс эрэгтэй төрөлд мөнгөн медаль, теннис эрэгтэй төрөлд мөнгөн медаль, шатар эмэгтэй төрөлд хүрэл медаль, биллъярд эмэгтэй төрөлд хүрэл медаль хүртсэн бахдам амжилтыг үзүүлж оролцлоо.



БҮСИЙН БОЛОН БУСАД КЛУБУУДЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ДЭМЖИХ

УБ болон Хүрээ Ротаракт клубуудээс зохион байгуулж буй арга хэмжээнүүдийг дэмжиж мөнгөн хандив хандивласан. Ротаричууд Цар тахлын эсрэг нэгдэж буй хандивын арга хэмжээг Зуунмод Ротари клубийн гишүүд эв санаа нэгтэй дэмжин хандив өгч мөн нийт Ротаричуудынхаа хандивын нэгээхэн хэсэг 100 хамгаалалтын хувцас, 2000 амны хаалтыг эрсдлийн өндөр бүсэд харьяалагдаж буй Төв аймаг болон Зуунмод хотынхоо Онцгой комисс-т хүлээлгэн өгсөн.



2020-2021 ОНЫ БҮСИЙН ЗАХИРАГЧИД БОЛОН БҮСИЙН УДИРДЛАГЫН БАГИЙН АЙЛЧЛАЛ



2020-2021 оны Ротарийн жилийн Бүсийн удирдлагын багийн гишүүд, Бүсийн Захирагчдын хамт Зуунмод Ротари клубт албан ёсны айлчлал хийж клубийн үйл ажиллагаа болон гишүүдтэй нөхөрсөг дотно ярилцлага зохион байгуулж орон нутагт нь үүссэн нөхцөл байдлын улмаас санаачлан хэрэгжүүлж буй төсөлд тусламж дэмжлэг үзүүлж ажиллаа.

“ЗУУНМОД – ЗУУН ХҮҮХЭД” ТӨСӨЛ

Цар тахлын хөл хорионы улмаас эцэг эх асран хамгаалагчид нь түр болон байнгын ажлын байр нь зогссон, өдөр тутмын орлогогүйгээс дулаан хувцасгүй өвөлжих нөхцөл байдалд орсон гэр бүлийн хүүхдүүдийн судалгааг гаргаж Зуунмод хотынхоо 100 хүүхдийг дулаан гутал, өвлийн гадуур хувцасаар хангах төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Одоогоор нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 79% нь төслийн хандив тусламжаар худалдан авсан хувцас, гутал, оймс, малгайг хүлээн аваад байна.

Энэхүү төсөлд Бүс, Ротари клубууд болон хувь хүмүүс байгууллагын хандиваар нийт 4,200,0₮ төгрөгийн хандив цуглараад байна. Бяцхан хүүхдүүдэд тусламжийн гараа сунган мөнгөн болон эд материалын хандив өргөсөн хүн бүхэнд баярлалаа.



СЭЛБЭ РОТАРИ КЛУБ ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ АРИЛГАХ ТӨСӨЛ

ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ХОР УРШИГ НЬ УТААНЫ БОХИРДЛООС Ч ИЛҮҮТЭЙГЭЭР АЮУЛТАЙ

Манай нийслэлчүүдийн ундны ус, хөрсний бохирдолд Монголчуудын амьдралын хэв загварын нэг хэсэг болох гэр хорооллын жорлон, муу ус зайлуулах нүхний цооног ихээхэн нөлөөлдөг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоогоор нэг хүн өдөрт дунджаар 200 грамм өтгөн, 1,5 литр шингэн ялгадас ялгаруулдаг байна. Ил задгай бохирын цооногийн хаягдлаас ялгардаг шивтрийн хий буюу аммиак нь хорт хийний төрөлд хамаарагддаг бөгөөд хорын зэрэглэлээрээ дөрөвдүгээрт багтдаг байна. Энэ нь эхийн урагт нөлөөлж гажиг, согогтой хүүхэд төрөх, цаашлаад хүнийг үргүйдүүлэх хор уршигтай. Мөн агаарт дэгдэж амьсгалаар дамжин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг болох нь батлагджээ. Одоогоор Улаанбаатар хотын хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын нүхэн жорлон болон ил задгай хогноос үүдэлтэй бөгөөд энэ нь утаанаас ч илүү аюултай болоод байгаа учраас уг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Сэлбэ Ротари клуб хөрс цэвэршүүлэх төслийн ажлыг эхлүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.

Энэ төслөө бид анх "Япон улсаас гаралтай 40 жилийн түүхтэй Ашигтай бичил биетээр ариутган цэвэршүүлэх ЕМ технологийг танилцуулсан Японы 2560 дүүргийн Мураками Ротари клубийн гишүүн Катог Сэлбэ Ротари клуб 2019 онд хүлээн авч уулзсанаар төслийн гараагаа эхэлж, улмаар хүн амын эрүүл, аюулгүй орчинг хангахын тулд нийслэлийн хэмжээний хөрсийг ариутгах, халдваргүйжүүлэх цаашлаад бохирдлын түвшинг бууруулж, эрүүлжүүлэх, бохирын үнэргүй болгох ажлыг тодорхой үе шаттайгаар төслөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн юм.

Уг төслийн эхний шатыг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Байгаль орчны газар, Шинжлэх Ухааны Академийн Хими, Химийн технологи, Газарзүй Геоэкологийн хүрээлэнгийн дэргэдэх "Гарааны Технологийн Инкубатор" ХХК-тай хамтран ОУ-ын

Ротарийн 3450 дүүргийн Сэлбэ Ротари клуб, ОУ-ын Ротаригийн 2560 дүүргийн Мураками, Мураками-Ивафүни ротари клубүүдтэй клубийн хоорондын хамтарсан төслөөр Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрийн хортой хүнд металл, нянгийн бохирдол ихтэй хөрсний 35,000 м2 буюу 3.5 га талбайн хөрсний бохирдлыг бууруулах, хөрсийг эрүүлжүүлэх болон гэр хорооллын 500 нүхэн жорлон, муу усны цооногийг ариутган халдваргүйжүүлэх ажлыг 35,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг 2020 оны 09 дүгээр сард амжилттай хэрэгжүүлсэн юм.

ЕМ технологиор үйлдвэрлэгдэж байгаа хөрсний бохирдол арилгах зориулалтаар ашигтай бичил биетээр бэлтгэсэн биобэлдмэл нь органик бохирдлыг задлах, хөрсийг эрүүлжүүлэх, ариутгах, экологийн тэнцвэрт байдлыг хангах онцгой үйлчилгээтэй бөгөөд одоогоор дэлхийн 120 гаруй оронд хэрэглэгдэн үр өгөөжөө өгсөөр байгаа, хүн амьтанд сөрөг нөлөөгүй экологийн цэвэр бүтээгдэхүүн юм.

Бид цаашид Сэлбэ Ротари клуб нь төслийн хоёр дахь үе шатанд уг технологийг ашиглан Нийслэлийн хэмжээний бүх хөрсний бохирдлыг бүрэн хэмжээгээр ариутгах ажлыг глобал грант төслөөр хэрэгжүүлэхээр зорилго тавин ажиллаж байна.





2020-21 Ротари жилийн эхний хагаст 3450 дүүргийн 9, 10-р бүсийн клубүүд даян дэлхийн сайн сайхны төлөөх Ротари сангаа үргэлж дэмжиж хамтран ажилладагт баярлалаа.

РОТАРИ САНгийн эрхэм зорилго нь Ротарийн гишүүдээр дамжуулан эрүүл мэндийг сайжруулах, боловсролыг дэмжих, ядуурлыг бууруулах замаар дэлхийд сайн санааны болон энх тайвныг хөгжүүлэх боломжийг олгодог.

Яагаад Ротари Санд Хандилах?

- Танай клубийн дэмжлэгтэйгээр Ротари Сан нь орон нутагт чиглэсэн төслүүд болон дэлхийн хэмжээний санаачлагуудыг хүмүүнлэгийн үйл ажиллагаатайгаа уялдуулан санхүүжүүлэхэд тусалдаг.
- Танай клуб эсвэл Ротари дүүрэг дэмжлэг хүсэх өргөдөл гаргаснаар төсөл хэрэгжүүлэх төсөв болон сургалтын тэтгэлэг авч болно. Ротари Сан нь халдварт саа өвчнийг устгах, энх тайвныг дэмжих зэрэг дэлхий дахины компанит ажлыг хэрэгжүүлж ирсэн.
- Ротари Сангийн сургалтын тэтгэлэг, мэргэжлийн сургалт зэрэг хөтөлбөрүүдэд оролцсоноор шинэ гишүүдийг татах, үндсэн гишүүддээ урам зориг өгөхөөс гадна тэдний нийгмийн идэвхийг улам нэмэгдүүлнэ.
- Ротари сан нь бие даасан сан бөгөөд та бидний сайн мэдэх Ротарийн төслийн грантуудад зориулагддаг. Бид бүхний энэ жил өргөсөн нийт хандив нь 3 жилийн дараах Грантад зориулагдан манай дүүрэгт хуваарилагддаг учраас бид бүхэн Ротари санд хандив өргөснөөр ирээдүйд хэрэгжүүлэх төсөлдөө хөрөнгө оруулж байгаа гэж ойлгож болно.

Ротари санд гишүүн бүр жил бүр 100 ам доллараас дээш хандив өргөхийг уриалдаг ба энэ жил Улаанбаатар, Хүрээ, Нарлаг Улаанбаатар, Улаанбаатар Пийс Авенью, Улаанбаатар Хангарьд клубүүдийн нийт гишүүдэд идэвхитэй хандив өргөж 100% EREY banner болзол хангасанд баяр хүргэж талархал дэвшүүлье.

Та бүхнийг цаашид ч бусдын төлөөх үйлсэд гар бие оролцон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхийн сацуу Ротари сандаа хандив өргөж дэмжихийг уриалж байна. Мөн Глобал Грант, Дүүргийн Грант хөтөлбөрүүдэд идэвхитэй хамрагдаж орон нутгийн болон олон улсын төслүүдэд хувь нэмрээ оруулна хэмээн найдаж байна.

ОУ Ротари 3450 дүүргийн Ротари Сангийн хорооны дэд дарга, PAG Б. Булган



ROTARY GLOBAL REWARD ХӨТӨЛБӨР

Хангарьд Ротари Клубийн 2020-21 оны Ерөнхийлөгч Ц.Ганхүү нь өөрийн бизнес болох Dandy Atelier дэлгүүртээ захиалгын хослолын 15%-ийн хөнгөлөлтийг нийт Ротаричууд болон Ротарактууддаа үзүүлэхээр **Rotary Global Reward** хөтөлбөрт албан ёсоор бүртгүүлээ.

Энэхүү хөтөлбөр нь үргэлж бусдын төлөө зүтгэж буй Ротарийн гишүүддээ өгч буй бэлэг бөгөөд гадаад дотоодын гишүүдэд үйлчлэх ба нөгөөтэйгүүр Ротаричууд бие биенийхээ бизнесийг дэмжих зорилгыг агуулдаг ба Монголын Ротаричуудын хувьд Best Western Tuushin Hotel, Beni Bana жуулчны бааз, MG travel зэрэг байгууллагуудын хөнгөлөлтүүд бүртгэгдсэн байдаг.

Dandy Atelier захиалгат хослолын дэлгүүрийн уг хөтөлбөрт элссэнтэй холбогдуулан 2020 оны 11-р сарын 6-ны өдөр бизнес эрхлэгч Ротаричуудыг урьж Rotary Global Rewards хөтөлбөрийг танилцуулах, бизнес нетворкинг хийх арга хэмжээг 9, 10-р бүсийн гишүүнчлэлийн хорооны зүгээс зохион байгууллаа.

Тус дэлгүүрийн албан ёсны хуудас:

<https://www.facebook.com/dandyatelier>

Та хөнгөлөлт эдлэхдээ өөрийгөө Ротарийн албан ёсны гишүүн болохоо батлахад л болно.

Мөн та өөрийн бизнесийг уг хөтөлбөрт бүртгүүлэх бол бидэнтэй холбогдоно уу.



DANDY

atelier



НАРЛАГ УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ

Нарлаг Улаанбаатар Ротари Клуб нь 2020-оны 7-р сарын 1-нээс Ерөнхийлөгч Н.Эрдэнэбаяраар ахлуулсан шинэ Удирдах зөвлөлийн бүтэцтэйгээр ажиллахдаа "Хичээлдээ бэлтгэе" хамтарсан төслийг санаачлан Баян-Өлгий аймагт 170 хүүхэд, нийслэлийн Сонгонохайрхан дүүрэгт 50 хүүхэд хичээлийн хэрэгслийн багцыг хандивласан үр дүнтэй ажиллаад байна. Мөн COVID-19 –тэй тэмцэх "REDrone" дүүргийн грант төсөл хэрэгжүүлэхээр Тамир Ротари клуб, JCI Капитал байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулаад Ковидын нөхцөлд Дроноор донорын цусыг илгээх төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. Бид энэхүү төслийн цар хүрээ, бүтээмжийг сайжруулахын тулд нэмэлт хөрөнгө оруулалтыг босгох шаардлагатай болсон тул хамтран ажиллах клуб, хувь хүмүүсийг нээлттэй урьж байна.

ТА БҮХЭН МАНАЙ ШИНЭ ГИШҮҮДТЭЙ ТАНИЛЦАНА УУ.



Равдангийн САРАНЧИМЭГ

GTN Anios Mongolia компанийн Ерөнхий Захирал, Absolut Mongolia Tour компанийн үүсгэн байгуулагч
Цахим хаяг: ravdansara@yahoo.fr,
Утас: 99089282
Клубийн ментор: Ерөнхийлөгч Н. Эрдэнэбаяр



Нямдоржийн ЭНХ-АМГАЛАН

Гранпри эмнэлгийн Ерөнхий Захирал
Цахим хаяг: enkhmagalann@gmail.com,
Утас: 99113414
Клубийн ментор: Ерөнхийлөгч Н. Эрдэнэбаяр



Мянганы БАДАМ

Төслийн мэргэжилтэн. Английн Манчестер Метрополитаны Их сургуульд төслийн менежментийн магестрийн зэрэг хамгаалсан.
Цахим хаяг: Badam.luck@gmail.com,
Утас: 91918368
Клубийн ментор: 2019-20 оны Ерөнхийлөгч Х. Уранхайч



Балдандоржийн АМАРЖАРГАЛ


Тимус Фарма ХХК-н Гүйцэтгэх захирал
Цахим хаяг: b.amarjargal@monos.mn,
Утас: 99990540
Клубийн ментор: 2020-21 оны Ерөнхийлөгч Н. Эрдэнэбаяр

МОНГОЛЫН РОТАРИ ГИШҮҮДИЙН ДУНД ХИЙСЭН АНХНЫ САНАЛ АСУУЛГА

Гишүүнчлэлийн хорооноос 2020 оны 8 сараас 10 сарын хооронд нийт Ротаричуудын дунд санал асуулга явуулж, нийт бүртгэлтэй 300 гаруй Ротаричуудын 165 нь оролцсоноор тус санал асуулгын дүнг гаргалаа. Санал асуулгын дүнгээс үзэхэд Ротаричууд ихэвчлэн найз нөхдийн хүрээллээс Ротаригийн тухай мэдээлэл авч Ротаригийн хөдөлгөөнд элсдэг байна. Аливаа клубын тогтмол үйл ажиллагаа /уулзалт, хурал/, төсөлд хөрөнгө босгох арга хэмжээнүүд

Ротаричуудад илүү их таалагддаг ба хүмүүст өргөнөөр тусалдаг, олон хүнтэй танилцах нөхцөлийг бүрдүүлдэг нь гишүүн байхын давуу тал гэж үзсэн байна. Клубуудын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтүүдээс клубуудын гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, Ротаригийн тухай ойлголтыг илүү олон хүнд таниулах талаас Бүсийн зүгээс анхаарч ажиллахыг дурджээ

ТА РОТАРИД НЭГДЭЭД ХЭДЭН ЖИЛ БОЛЖ БАЙГАА ВЭ?



ТА АЛЬ КЛУБЫН ГИШҮҮН ВЭ?

